



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 431

Улаанбаатар хот

### Б.Халиуныг ажилд түр томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 19 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТӨГТООХ нь:

1. Гадаад харилцааны сайдын 2024 оны 08/3194 тоот албан бичгээр ирүүлсэн санал болон Авлигатай тэмцэх газрын 2024 оны "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай" 05/15334 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын ажлыг Б.Халиунд хүлээнлэх ажлыг зохион байгуулж, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ) тус тус үндэслэн захирлаар түр томилсугай.

2. "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын нээлттэй сонгон шалгаруулалтыг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан зохих журмын дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын нээлттэй сонгон шалгаруулалтыг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан зохих журмын дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

4. Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх замаар нийтийн албан үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Б.Халиунд даалгасугай.

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.



ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ